



Golomt Capital®

# Валютын зах зээлийн ТОЙМ

ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК- Д БЭЛТГЭВ

2022.05.30

*Дотоодын зах зээл  
Олон улсын зах зээл*

## ДОТООДЫН ВАЛЮТЫН ЗАХ ЗЭЭЛИЙН СУУРЬ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

2022 он 05 сарын 30


Ханшийн өөрчлөлт	Албан ханш	Долоо хоног	Оны эхнээс	Жил
	3,121.05	0.296%	9.549%	9.559%

**Товч дүгнэлт:**

Өнгөрсөн 7 хоногт ам.долларын ханш төгрөгийн эсрэг 0.296 хувиар чангарлаа. Төгрөгийн ханшийн тогтвортой байдлыг хангах Төв банк интервенцийг нэмэгдүүлж байгаа ч эрэлт өндөр байгаа тул ам.долларын ханш төгрөгийн эсрэг чангарсаар байна.

**Монголбанкны дуудлага худалдаа:**

Өнгөрсөн 7 хоногт Монголбанк банкнуудын 102.9 сая ам.доллар худалдан авах хүсэлтийг зах зээлд нэг ханшаар нийлүүлсэн байна. Харин банкууд 10 сая ам.долларын своп хэлцэл байгуулах саналыг 2 удаа ирүүлсэн бол Монголбанк биелүүлээгүй байна.

**Гадаад худалдаа:**

2022.05.26-нд Гашуунсухайт боомтын төмөр замын шилжүүлэн ачих терминалын бүтээн байгуулалтын нээлт болж 14 жил гацаад байсан экспортын ачаа шилжүүлэн ачих байгууламжийн бүтээн байгуулалтын ажил эхэллээ. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр зам 7 сард, Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр зам 11 сард ашиглалтад орох төлөвтэй байна.



**Мэдэгдэл:** Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.

## ОЛОН УЛСЫН ВАЛЮТЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2022 оны 5-р сарын 30

	Хаалтын ханш	7 хоног	1 сар	1 жил
DXY	101.51	-0.57%	-1.48%	12.8%
EURUSD	1.0754	0.59%	2.00%	-12.05%
USDCNY	6.6680	-0.36%	1.00%	4.8%
USDRUB	66.7	15.26%	-6.00%	-9.17%
USDJPY	126.95	-0.70%	-2.2%	15.91%
AUDUSD	0.7183	0.31%	1.68%	-7.14%

## DXY ханшийн хөдөлгөөн:

Өнгөрсөн долоо хоногт ам.долларын ханш олон улсын зах зээл дээр голлох валютуудын эсрэг бага зэргийн чангарах хөдөлгөөн үзүүлээ. Ханшийн өөрчлөлтөд дараах хүчин зүйлс голлон нөлөөллөө.

- 5 сард сүүлийн 20 жил дэх хамгийн өндөр өсөлтөө үзүүлсэн ам.долларын ханш эдийн засгийн үзүүлэлтүүд эерэг гарч бодлогын хүүг цаашид эрчтэй нэмэгдүүлэх шаардлагагүй гэсэн мэдээлэлтэй холбоотойгоор засварын уналтад орлоо. Тодруулбал 4 сард АНУ-ын жижиглэн худалдаа өсөлттэй гарснаар инфляцын өсөлт саармагжих төлөвтэй байгаа юм.
- ХНС-ийн хурлын тэмдэглэлд ирэх 6, 7 сарын нээлттэй захын хурлаар бодлогын хүүг 50 нэгжээр нэмэгдүүлэх талаар гишүүд санал нэгтэй байгааг дурдсан бөгөөд амлаж байсныхаа дагуу бодлогын хүүг өсгөх төлөвтэй байгаа нь ханшийг өсгөх шалтгаан болж чадсангүй.

## График 3 : DXY /ам.долларын индекс/-ийн 7 хоногийн лаа



**Мэдэгдэл:** Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.